

**ТУСГАЙ НӨХЦӨЛТ ЦАЛИНГИЙН ЗЭЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2023/02/17-ны өдөр

№23/01

2023/13

Улаанбаатар хот

Энэхүү ЦАЛИНГИЙН ЗЭЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх):

**Нэг талаас:**

Банк	Банкны нэр:	Капитрон банк ХК (цаашид “Банк” гэх)
	Хаяг:	СБД-ийн 2-р хороо, Усны гудамж-4
	Улсын бүртгэлийн дугаар:	9008001011
	Регистрийн дугаар:	2677377
Банкыг төлөөлөх эрх бүхий этгээд	Албан тушаал:	Баянгол салбар
	Нэр:	Д.Энхтунгалаг

**Нөгөө талаас:**
**Гэрээт байгууллага**

Хуулийн этгээд	Байгууллага	Хуулийн этгээдийн нэр, хэлбэр:	Амгалан дулааны станц ТӨХК (цаашид “Байгууллага” гэх)
		Улсын бүртгэлийн дугаар:	9011573097
		Регистрийн дугаар:	6021646
		Хаяг:	УБ хот, БЗД-ийн 8-р хороо, Ус 15, 0 тоот
		Харилцах дансны дугаар:	3004012002
	Түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд-1	Албан тушаал:	Гүйцэтгэх захирал
		Овог:	Зуутраг
		Эцэг/Эхийн нэр:	Мягмар
	Түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд-2	Өөрийн нэр:	Мөнхөө
		Албан тушаал:	Нягтлан бодогч
		Овог:	Боржигин
		Эцэг/Эхийн нэр:	Өнөрбат
	Түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд-2	Өөрийн нэр:	Удвал

нар (цаашид “Банк” болон “Байгууллага”-ыг хамтад нь “талууд” гэх) нь харилцан тохиролцож, дор дурдсан нөхцөлөөр хамтран ажиллахаар харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Гэрээний зорилго нь Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Банкны “Хэрэглээний зээлийн журам”-д тус тус нийцүүлэн байгууллагын ажиллагсдын цалинг Банкн дахь нэрийн дансаар дамжуулан олгох, Банкны зүгээс дотоод дүрэм журамд заасны дагуу зээлжих чадвар хангасан байгууллагын ажилтанд Цалингийн зээл олгох, зээлийн өр төлбөрийг тухайн ажилтны нэрийн данснаас суутган авах, төлүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**ХОЁР. ҮНДСЭН НӨХЦӨЛ**

- 2.1. Талууд гэрээний үндсэн нөхцлийг дараах байдлаар харилцан тохиролцов. Үүнд:
- 2.1.1. Гэрээний хугацаа: 1 /Нэг жил/
- 2.1.2. Ажилтнуудад олгох зээлийн нөхцөл: Энэхүү нөхцөл нь дараах зарчмаар тодорхойлогдоно. Үүнд:
- 2.1.2.1. Зээлийн хэмжээ: 18 сарын бодит цалинтай тэнцэх буюу дээд хэмжээ 50,000,000.00 /Тавин сая/ төгрөг хүртэл
- 2.1.2.2. Зээлийн хугацаа: 30 сар
- 2.1.2.3. Зээлийн хүү: жилийн 18.0%
- 2.1.2.4. Зээлийн үйл ажиллагааны шимтгэл: 1.0%
- 2.1.2.5. Зээлийн өргөдлийн хураамж: 1,000.00 /Нэг мянга/ төгрөг
- 2.1.2.6. Барьцаа хөрөнгө:
- 20.0 сая төгрөг хүртэл цалингийн орлого
  - 20.0 сая төгрөгөөс дээш үл хөдлөх хөрөнгө болон хөдлөх хөрөнгө барьцаалах
- 2.1.2.7. Нэмэлт нөхцөл:
- Тухайн байгууллагад 6 сараас дээш хугацаанд үндсэн ажилтнаар ажилласан байх,
  - Капитрон банкны дансаар дамжуулж цалингаа авах,
  - Байгууллагын удирдлагын тодорхойлсон ажилтан байх,
  - Бусад банк санхүүгийн байгууллагын цалингийн зээлийг шилжүүлж авах, зээл авсан өдрөөс Капитрон банкинд цалингийн дансаа шилжүүлэх,
  - Бусад нөхцөл БҮЕН-ийн дагуу байна.

**ГУРАВ. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Банк нь дараах үүрэгтэй. Үүнд:

- 3.1.2. Цалинг нэрийн дансаар дамжуулан олгох үйлчилгээтэй холбоотой санал гомдол, хүсэлт шаардлагыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх ба шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх.
- 3.2. Банк нь дараах эрхтэй. Үүнд:
  - 3.2.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах;
  - 3.2.2. Байгууллага болон Зээлдэгчийг гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах;
  - 3.2.3. “Цалингийн зээлээр хамтран ажиллах гэрээ” байгуулсан байгууллагын ажиллагсад олгосон нийт зээлийн багцад хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн эзлэх хувь 1 хувиас дээш гарсан тохиолдолд банк нэмж зээл олгохгүй байх;
  - 3.2.4. Цалингийн зээлийн гэрээний үүргийн зөрчил үүссэн талаар Байгууллагад мэдэгдэж, зээл төлөхөд шаардлагатай мэдээлэл, дэмжлэг авах.

#### ДОРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Байгууллага нь дараах үүрэгтэй. Үүнд:
  - 4.1.1. Шинээр ажилд орсон болон цалингийн зээл авах хүсэлтэй ажилтны цалинг Капитрон банкинд дахь нэрийн дансаар дамжуулан тавьж олгох зохион байгуулалтыг тухай бүр хийх;
  - 4.1.2. Төрийн сангаас тус банкны дансаар цалингаа авах боломжийг бүрдүүлж ажиллах;
  - 4.1.3. Байгууллагын ажилтан нь зээл авах хүсэлт гаргасан тохиолдолд гэрээний хавсралтанд заасан маягтын дагуу зээл хүссэн ажилтны үндсэн цалингийн хэмжээ болон ажил байдлын тодорхойлолтыг банкинд үнэн зөв тодорхойлж өгөх;
  - 4.1.4. Тодорхойлолтыг зөвхөн мэргэжлийн ур чадвар сайтай, зээл төлж дуусгах хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах боломж бүхий байгууллагын үндсэн ажилтанд гаргаж өгөх;
  - 4.1.5. Банкнаас зээл авсан ажилтны цалинг зээлийн гэрээний хугацаанд зөвхөн Капитрон банкны дансаар олгохоор зохион байгуулах бөгөөд зээлийн гэрээний үүрэг дуусаагүй үед цалин хүлээн авах банкныг солихгүй байх;
  - 4.1.6. Ажиллагсдын цалинг цаг хугацаанд нь олгож байх шаардлагатай зохион байгуулалтыг хийж ажиллах;
  - 4.1.7. Зээл авсан ажилтан ямар нэг шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн эсвэл 1 сараас дээш урт хугацааны чөлөө авсан тохиолдолд хуанлийн 3 /гурав/ хоногийн дотор албан ёсоор банкинд мэдэгдэж байх;
  - 4.1.8. Байгууллага нь энэхүү гэрээний 2.1.2-т заасан зарчмыг зөвшөөрч, заалтыг дагаж мөрдөнө.
- 4.2. Байгууллага нь дараах эрхтэй. Үүнд:
  - 4.2.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах;
  - 4.2.2. Банкнаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг шаардах.

#### ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1. Байгууллагын дараах буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан зээлдэгчийн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр төлөгдөөгүй тохиолдолд нийт төлбөрийг байгууллага барагдуулна. Үүнд:
  - 5.1.1. Зээлдэгчийн цалинг цаг хугацаанд нь олгоогүй;
  - 5.1.2. Зээлдэгчийн цалинг нэрийн данс руу нь шилжүүлээгүй;
  - 5.1.3. Ажилтны тодорхойлолтыг буруу гаргаж өгсний улмаас зээл төлөгдөхгүй болсон;
  - 5.1.4. Байгууллага ажилтны өмнө хууль болон гэрээгээр хүлээсэн бусад үүргээ зөрчсөн үйлдлүүдийн улмаас.
- 5.2. Байгууллага нь ажилтнуудын цалин болон цалингийн зээлтэй ажилтнуудын зээл, зээлийн хүүгийн төлбөрийг бэлэн бусаар төлсөн тохиолдолд Банкны холбогдох дансанд орж ирсэн өдрөөр төлбөр хийгдсэнд тооцно.
- 5.3. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

#### ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Талууд энэхүү гэрээнд харилцан тохиролцсоны дагуу нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэгдэж, талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2. Энэхүү гэрээтэй холбогдон үүсэх аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд эс хүрвэл хуулийн дагуу эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 6.3. Энэхүү гэрээний хугацаа дууссан, гэрээг цуцалсан тохиолдолд гэрээг байгуулсан өдрөөс хойш тухайн байгууллагын зээл авсан бүх ажилтнууд зээлийн төлбөрийг /үүнд: зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү адил хамаарна/ бүрэн барагдуулж дуустал гэрээний талуудын хүлээх үүрэг хариуцлага хүчин төгөлдөр хэвээр байна.
- 6.4. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр хуулийн адил хүчинтэй байна.

#### ДОЛОО. ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ, ХАРИЛЦАХ УТАС

- 7.1. Капитрон банкны хаяг:  
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Усны гудамж 4, Төв байр  
Утас: 75115555
- 7.2. “Амгалан дулааны станц” ТӨХК-н хаяг:  
Монгол Улс, УБ хот, БЗД-ийн 8-р хороо, Ус 15, 0 тоот  
Утас: 77110351

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

КАПИТРОН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Баянгол салбарын захирал

..... Д.Эхтунгалаг/

Харилцааны менежер



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ийг  
ТӨЛӨӨЛЖ:

Захирал

...../М.Мөнхөө/

Ерөнхий нягтлан болоч